

“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ийн

Гүйцэтгэх захирал

Дун Шиан Руи

ӨМНӨГОВЬ АЙМАГ, НОЁН СУМЫН

“БАРУУН НОЁН УУЛ” НЭРТЭЙ НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ АШИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР-МҮ-017301/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР-5671833/

Хянасан:

БОАЖ-ын газрын мэргэжилтэн

/ Б. Оргилмаа /

Өмнөговь аймгийн БОХУБайцаагч

/ Д. Ичинноров /

Боловсруулсан:

Байгаль орчны мэргэжилтэн

/ Б. Буяндэлгэр /

/ Э.Түвшинбаяр /

2023 ОН

ГАРЧИГ

1. Төслийн товч танилцуулга	6
2. Байгаль орчны төлөв байдал	7
2.2.1. Суурь нөхцөл байдал:	11
2.2.2. Хөрсний дулаан хүйтэн:	13
2.2.3. Төслийн район орчмын уур амьсгалын ирээдүйн төлөв:	15
3. ТӨСЛӨӨС ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	17
1. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	22
4.1	22
4.2	27
4.3	28
1. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ	38
5.1.1 Агаар орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ:	38
5.1.2 Гадаргын болон газар доорхи ус сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ:	46
5.1.3 Хөрсөн бүрхэвч үзүүлэх сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээ:	50
5.1.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ:	52
5.1.5 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ:	54
5.2.1. Техникийн нөхөн сэргээлт:	55
5.2.2. Биологийн нөхөн сэргээлт:	57
5.5.1 Техникуудэд засвар үйлчилгээ хийх зориулалт бүхий ШТМ хадгалалт, тээвэрлэлт, асгаралтанд хяналт тавих:	67
5.5.2 Гал түймрийн осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт:	68
5.7.1 Агаарын шинжилгээ:	75
5.7.2 Усны шинжилгээ:	80
5.7.3 Хөрсний шинжилгээ:	86

“ХҮР ЭРДЭНЭ БАЯЛАГ”ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Товч тодорхойлолт.....	6
Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн бүхий талбайн солбилцлын цэгүүд.....	7
Хүснэгт 3. Агаарын температурын сарын дундаж,	11
Хүснэгт 4. Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа,.....	17
Хүснэгт 5. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний хэрэгжилт	22
Хүснэгт 6. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	27
Хүснэгт 7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хэрэгжилт	28
Хүснэгт 8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.....	29
Хүснэгт 9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	30
Хүснэгт 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	31
Хүснэгт 11. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	32
Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.....	35
Хүснэгт 13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын хэрэгжилт.....	36
Хүснэгт 14. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг тайлагнах	37
Хүснэгт 15. 2023 оны БОМТ-ийн зардал.....	90

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн байршлын зураг.....	6
Зураг 2. Байгалийн бүс бүслүүр	7
Зураг 3. Төслийн район орчмын газарзүйн байршил	11
Зураг 4. Агаарын дулаан хүйтний жилийн явц	12
Зураг 5. Төслийн район орчмын жилийн дундаж агаарын температурын газарзүйн тархалт	13
Зураг 6. Агаар, хөрсний гадаргын сарын дундаж температурын жилийн явц	13
Зураг 7. Хөрсний гүний температурын жилийн явц	14
Зураг 8. Агаарын температурын өөрчлөлт, (°C) 2020 онд	15

**“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Зураг 9. Агаарын температурын өөрчлөлт, (°C) 2050 онд	15
Зураг 10. Хур тунадасны өөрчлөлт, (мм) 2020 онд	16
Зураг 11. Хур тунадасны өөрчлөлт, (мм) 2050 онд	16
Зураг 12. Уурхайн технологийн замыг усалж буй байдал.	38
Зураг 13. Гаалийн талбайг усалж буй байдал.	39
Зураг 14. Тэмдэг, тэмдэглэгээ	40
Зураг 15. Зам засвар хийж буй байдал.	41
Зураг 16. Уурхайн тосгоны зүлэгний ургалт.	42
Зураг 17. Уурхайн тосгоны зүлэгний ургалт-2.	43
Зураг 18. Уурхайн тосгонд ургаж буй моднууд-1	44
Зураг 19. Уурхайн тосгонд ургаж буй моднууд-2	45
Зураг 20. Цоохондойн задгай усыг сувагчлан засварлах,	46
Зураг 21. Цоохондойн цөөрөм.	47
Зураг 22. Байгаль орчны мэргэжилтэн сургалт орж буй байдал.	48
Зураг 23. Өөрчлөлтийг хурдасгая тэмдэглэлт өдөр	49
Зураг 24. Уурхайн тосгоны техник парклах талбайг бүрэн бетондсон.	50
Зураг 25. ШТМ-ын агуулах.	51
Зураг 26. Мод тарьсан талбай	52
Зураг 27. 5500 суулгац суулгах ажлын үйл явц.	53
Зураг 28. 2023 оны Биотехникийн арга хэмжээ	54
Зураг 29. Уурхайн шимт хөрсний овоолгыг хэлбэршүүлэн зассан байдал.	55
Зураг 30. Шимт хөрсний овоолгыг засч буй байдал.	56
Зураг 31. Шимт хөрсний овоолгын үрлэгээний ажил-1	57
Зураг 32. Шимт хөрсний овоолгын үрлэгээний ажил-2	58
Зураг 33. Шимт хөрсний ургамлын ургалтын явц.	59
Зураг 34. 2023.06.02-2023.07.25 хооронд ургалсан ургалт	60
Зураг 35. Цагаан толгойн талд гаргасан нарны үүсгүүрээр ажиллах автомат худаг.	61
Зураг 36. Хар сүүлтийн хөл газрууд.	62
Зураг 37. 2023.09.17 маршрутын дагуу ажиглалтанд өртсөн хар сүүлтүүд.	63
Зураг 38. Түүх, соёлын өвийг хамгаалах ажлын хүрээнд хийгдсэн судалгааны ажлын дүгнэлтүүд.	65

**“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Зураг 39. Судлаач нарын багийн ажлын үйл явц.....	66
Зураг 40. Засвар механикийн хэсгийн төлөвлөлт	67
Зураг 41. Ажилчдын сургалт.....	68
Зураг 42. Гал унтраах үзүүлэх сургалт.	69
Зураг 43. ШТМ-ын хаягдлыг цуглуулах ёмкомт.	71
Зураг 44. Ангилан ялгах хогийн сав.....	72
Зураг 45. Ахуйн хаягдал түр хадгалах цэг.....	72
Зураг 46. Хаягдал дугуйн ашигласан байдал.	73
Зураг 47. Гар багаж ашиглан тоосны хэмжилт хийдэг.....	75
Зураг 48. "Ногоон титэм" ХХК итгэмлэгдсэн лабораторийн ажилтан сорьц цуглуулан шинжилгээ авч буй байдал.....	78
Зураг 49. Ойр орчмын худгийн хэмжилт.....	80
Зураг 50. Хөрсний зүсэлт хийж буй байдал.	86
Зураг 51. Сайран багийн хуралд компанийн танилцуулга болон 2022 оны БОМТБТ-г тайлагнасан.....	89

ГРАФИК

График 1. Гар багажаар хэмжсэн тоосны хэмжилт-1	76
График 2. Гар багажаар хэмжсэн тоосны хэмжилт-2.....	77
График 3. Агаарын химийн найрлага.....	79
График 4. Худгийн хэмжилт-1.....	81
График 5. Гар худгийн хэмжилт-2	82
График 6. Усны нянгийн хэмжилт	83
График 7. Ус нөөцлөх сав сольсны дараах нянгийн хэмжилт.....	83
График 8. Ундны усны худгийн химийн найрлага-1.....	84
График 9. Худгийн усны химийн найрлага-2	85
График 10. Хөрсний хүнд металлын шинжилгээ-1	87
График 11. Хөрсний хүнд металлын шинжилгээ-2	88

“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


1.1 Төслийн нэр: Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт орших “Баруун ноён уул” нэртэй чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл.

1.2 Төсөл хэрэгжүүлэгч компани: Төсөл хэрэгжүүлэгч “Хур эрдэнэ баялаг” ХХК нь 2013 онд уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдсан 100% БНХАУ-ын хөрөнгө оруулалтай аж ахуйн нэгж юм.

Хүснэгт 1. Товч тодорхойлолт

Аж ахуйн нэгжийн нэр	“Хур эрдэнэ баялаг” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	39019071068
Регистрийн дугаар	5671833
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл	MV-017301
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон огноо	2013.04.17
Ашиглалтын талбай	1085.2 га
Хаяг	Өмнөговь аймаг, Ноён сум хот, Сайран баг, Цагаан дэрс

1.3 Төслийн байршил:



Зураг 1. Төслийн байршлын зураг

**“ХҮР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**


Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн бүхий талбайн солбилцлын цэгүүд

№	Уртраг	Өргөрөг
1.	102° 23' 4.9"	43° 6' 0.26"
2.	102° 23' 4.9"	43° 5' 29.58"
3.	102° 30' 0.89"	43° 5' 29.58"
4.	102° 30' 0.89"	43° 5' 1.29"
5.	102° 22' 0.8"	43° 5' 1.31"
6.	102° 22' 0.8"	43° 6' 0.26"

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1 Төсөл хэрэгжих орчны байршил, физик газарзүйн нөхцөл:

Өмнөговь аймгийн Ноён сум нь Монгол орны физик газарзүйн мужлалаар газрын гадаргын хувьд Алтайн уулархаг их мужийн Говийн-Алтайн мужид багтдаг. Төслийн нутаг дэвсгэрт Эхэн хайлааст уул (1873м), Дэнгийн нуруу (1975м), Дөрвөлжин уул (1612м)-с орших бөгөөд талбайн ойролцоох уулс толгод нь д.т.дээш 1600-1900м, мөн Гурвантэс-Борзонгийн говийн элсний мужид хамаарагдах Жарангийн элс байрлана. Уулсын онцлог нь гүн сайраар нилээд хэрчигдсэн, маш эгц хажуутай, харьцангуй тэгш хэмт байдалтай юм. Уулсаас эх авсан сайрууд нь хуурай зарим хэсэгтээ овоо өргөн бөгөөд урт нь хэдэн км-ээс хэдэн арван км хүрнэ.



Зураг 2. Байгалийн бүс бүслүүр

“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ”ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Аймгийн нутаг нь говь цөлийн мужид багтах бөгөөд дунджаар далайн түвшнээс дээш 1300-1600 м өндөрт оршино. Энд Алтайн нурууны үргэлжлэл Гурвансайхан, Сэврэй, Ноён богд, Номгон, Тост, Нэмэгт, Алтан уул, Гилбэнт зэрэг далайн түвшнээс дээш 3000 м хүртэл өндөр өргөгдсөн уул нурууд болон 100 гаруй км үргэлжилсэн Хонгорын элс, хэдэн 100 км өргөн Галба, Борзон, Зээмэг, Заг, Сүүжийн алдарт их говиуд бий.

Тус орд нь нутаг дэвсгэрийн мужлалын хувьд Алтайн уулархаг мужийн Говь-Алтайн мужийн Говь-Алтайн зүүн тойрогт багтдаг.

Олборлолтын талбай нь Эхэн Хайлаастын синклиналийн баруун хойт хэсэгт байрших ба нүүрсний давхраас агуулагч дээд пермийн Дэлийн шанд формацын хурдас нь хойт хэсгээрээ дунд-дээд карбонь Тост формацын андезит-базальтаас тогтох эффузив зузаалаг болон түүнийг зарим хэсгээрээ тасалдалтайгаар хучих доод пермийн Тогоот хар формацын риолит, риодацитаас тогтох хүчиллэг зузаалаг дээр угаagdлын гадаргуугаар хилэлдэг болно. Дэлийн шанд формац хайгуулын талбайн энэ хэсэгт бараг бүхэлдээ дээд дөрөвдөгч-орчин үеийн сэвсгэр хурдсаар хучигдах боловч гуу жалгаар хэрчигдэж идэгдсэн хэсгийн хоёр захаар байнга ил гардаг гаршийн уналын азимут нь 170-200⁰, налууугийн өнцөг нь 35-40⁰ байна.

Уул зүй:

Тус ордын талбай нь газрын гадаргын хувьд Говь-Алтайн уулсын дундах тал хээрийн бүсэд орших ба ихэнх хэсэг нь бэсрэг уулс толгодорхог гадаргуутай газруудыг хамарна.

Талбайн хамгийн өндөрт өргөгдсөн цэг нь талбайн хойд хэсэгт карьерын зүүн хойно орших далайн түвшнээс дээш 1703 м өндөрт өргөгдсөн уулын орой болно. Хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 1560 м өндөртэй талбайн зүүн өмнөд хэсэг дэх жалга болно.

Ус зүй

Ус зүй, гадаргуугийн усан сүлжээний хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг бөгөөд тогтмол урсацтай гол горхи, нуур, цөөрөм байхгүй гадаргын ус ховортой бүсэд багтана. Энд зөвхөн уулс хоорондын хотгорт жижиг шал, тойром бүхий газарт хур бороо ихтэй үед уулсын жижиг ам, хөндий хуурай сайраар түр зуурын урсац бүхий ус урсаж хотгоруудын ёроолд хурж тогтох ба сэвсгэр хурдсан доогуур шурган замхардаг.

Талбайн хэмжээнд байнгын урсгалтай гол горхи бараг байхгүй боловч зарим үедээ усны ажиллагаа нилээд идэвхждэг болохыг гэрчлэх ор мөр цөөнгүй бий. Талбайд уртрагийн дагуу чиглэлтэй голын хуурай сайр түүнд цутгах жижиг сайрууд, хэрчигдэл багатай хөндийнүүд хөгжсөн байна. Цас их орж хайлах үргэлжилсэн бороо орох зэрэг үед эдгээр

“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ”ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

сайр нь бага зэрэг устай болох боловч бороо татрахад усгүй болно. Хур бороотой үед жижиг хонхор хотгор газарт жижиг нуурууд бий болох ба тэдгээр нь элс, булингартай усаар дүүрдэг.

Хүн малын унданд бага гүнтэй, гар худгийн ус хэрэглэх бөгөөд худгуудыг голчлон хуурай сайр, нуурын зах хөвөөг бараадуулан гаргасан байдаг. Худгийн түвшин нь 5-6 м-т заримдаа 9-10 м-т хүрдэг.

Хөрс:

Монгол орны ургамал, газарзүйн мужлалаар Алтайн уулархаг их мужийн ГовьАлтайн зүүн тойрогт багтах ба энэ талбайн хөрс нь Монгол орны байгалийн бүсийн хуурай хээр, заримдаг цөлийн бүсэд хамрагдана. Говийн цайвар бор хөрс, уулын цөлөрхөг хээрийн бор саарал хөрс, хужирлаг говийн бор саарал, цөлөрхөг хээрийн бор хөрс, уулын цөлийн бор саарал хөрс, цөлөрхөг хээрийн бор хөрс, элсэрхэг говийн бор хөрс зэрэг хэв шинжийн хөрс тархсан байна. Ургамлын хувьд Монгол орны ургамалгазарзүйн мужлалаар Өмнөговь аймаг нь Говь-Алтайн уулын цөлөрхөг хээр, Алшаа говь, Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт багтдаг. Ургамлын зүйлийн бүрдлийн 21.4% нь хуурайсаг, 21.3% нь хуурайсуу-чулуусаг, 15.5% нь чийгсүү-давссаг, 10.2% нь чийгсүү-хуурайсаг, 6.5% нь элсэн дасалттай ургамал бөгөөд сөөг, сөөгөнцөр ургамлын бүлгэмдэл зонхилно.

Ургамал зүй:

Ургамлын хувьд Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Өмнөговь аймаг нь Говь-Алтайн уулын цөлөрхөг хээр, Алшаа говь, Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт багтдаг. Ургамлын зүйлийн бүрдлийн 21.4% нь хуурайсаг, 21.3% нь хуурайсуучулуусаг, 15.5% нь чийгсүү-давссаг, 10.2% нь чийгсүү-хуурайсаг, 6.5% нь элсэн дасалттай ургамал бөгөөд сөөг, сөөгөнцөр ургамлын бүлгэмдэл зонхилно.

Амьтны аймаг:

Амьтдын хувьд Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр нь амьтны аймгийн газарзүйн мужлалаар Хойт говь, Говь-Алтай, Алтайн өвөр говийн тойрогт багтана. Уг нүүрсний орд орчмын газар нутагт том хөхтөнөөс Янгир ямаа, хавтгай тэмээ тэмдэглэгдсэн байна. Жижиг хөхтөн, хоёр нутагтан ба мөлхөгчид зэрэг зарим амьтдын зүйлийн бүрдлийг харвал Цөлийн хөхтөний бүлгэмдлээс Боролзон туулай, Элссэг зузга, Бордуу шишүүхэй, шаргал чичүүл, морин цөцүүл, шивэр алагдаага, Өмнөговийн алагдаага, Элсч савгадаахай, Гувруу тажигдаахай зэрэг амьтад байна.

Уур амьсгал:

Нутгийн хойг хэсгээр Хангай, Говь-Алтайн уулсын нөлөө, өмнөд хэсгээр говийн нөлөө мэдэгдэхүйц байдаг. Уур амьсгалын хувьд нэн хуурай, дулаавтар, Говь-Алтайн цөлөрхөг хээрийн мужид хамрагдах бөгөөд агаарын жилийн дундаж температур 2-4°C, сүүлийн 3 жилийн дунджаар 2.6-4.2°C болсон нь олон жилийн дундажаас харьцангуй өндөрт тооцогдоно. Олон жилийн дундаж салхины хурд 3-5 м/с, сүүлийн жилүүдийн салхины дундаж хурд 4-6 м/с болж, 15 м/с- ээс дээш салхитай өдрийн тоо жилд 15-20, хамгийн их салхины хурд 40 м/с хүрдэг.


Агаарын үнэмлэхүй их температур +45°C-аас их, үнэмлэхүй бага температур - 40°C-аас хүйтэн болох нь бий. Зун нь аагим халуун, өвөл нь цас бага дулаахан хуурай байдаг. Агаарын жилийн дундаж температур +4°C-аас +6°C хамгийн их халуун нь 7 сард +38°C-аас +40°C-д хүрч халдаг. Тус сумын нутагт дулааны хангамж сайтай, жилийн цэлмэг өдрийн тоо 120-150 өдөр, жилд нар гийгүүлэх хугацаа 3200 орчим цаг байдаг. Харин чийгийн хэмжээ бага, жилд орох хур тундасны хэмжээ олон жилийн дунджаар 50-110 мм байсан бол сүүлийн жилүүдэд энэ хэмжээ багасаж дунджаар 60-100 мм тунадас орох ба үүний 70- 80% нь 7-8 сард унана. Жилийн хамгийн халуун сар нь 7 дугаар сар буюу дунджаар +21.9°C дулаантай бол жилийн хамгийн хүйтэн сар нь 1 дүгээр сар буюу дунджаар -11.3°C хүйтэн байна. Жилийн температурын зөрүү нь 33.2°C. Жилийн хамгийн намдуу буюу салхи багатай сар нь зун, өөрөөр хэлбэл 7 дугаар сар хамгийн бага салхитай байна. Салхины зонхилох чиглэл нь баруун болон баруун хойд зүгээс байна.

2.2 Цаг уур болон уур амьсгалын өөрчлөлт

Ордын талбай нь Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт Улаанбаатар хотоос баруун урагш 800 км-т, Ноён сумын төвөөс зүүн урагш 30 км-т, Гурвантэс сумаас зүүн урагш 110 км-т далайн түвшнээс дээш 1430-1670 м өндөрт оршино. Ноён сум нь баруун талаараа Гурвантэс, хойд талаараа Сэврэй, Зүүн талаараа Баяндалай сумуудтай тус тус хиллэдэг.

Иймээс энэхүү уур амьсгалын тодорхойлолтыг хамгийн ойр орших Ноён цаг уурын харуулын /хоногт 3 ажиглалттай/ болон Гурвантэс /хоногт 8 ажиглалттай/ цаг уурын өртөөний мэдээг тулгуур болгон ашиглав.

**“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ”ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



Зураг 3. Төслийн район орчмын газарзүйн байршил

2.2.1. Суурь нөхцөл байдал:

Уур амьсгалын ерөнхий нөхцөл байдал:

Монгол улс бол эх газрын эрс тэс уур амьсгалтай, маш хүйтэн, урт өвөлтэй бөгөөд жилийн хур тунадас болон агаарын чийгшил багатай, богино зуны улиралтай юм.

Улирлын хэлбэлзэл:

Төслийн районд жилийн дундаж агаарын температур (1964-2020 оны дундаж) 4.0 (±1.8)⁰C орчим байна. (Хүснэгт 3)


Хүснэгт 3. Агаарын температурын сарын дундаж,
үнэмлэхүй хамгийн их болон бага утга /⁰C-ээр/

Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Гурвантэс цаг уурын өртөө													
T1971-2020	-13	-9.1	-2.8	6.1	13.6	19	21	19	13	4.9	-4.2	-11	4.8
Tmax	7.8	11	20	27	32	36	41	34	32	24	16	12	41
Tmin	-33	-32	-27	-17	-11	2.3	5	3.2	-5.4	-19	-25	-31	-33
Ноён цаг уурын харуул													
T1964-2020	-13	-10	-3.9	5	12.3	18	20	18	13	4.5	-5	-11	4
T1983-2020	-13	-10	-3.5	5.4	12.7	19	21	18	13	4.4	-5.2	-11	4.2
Tmax	7.1	8.9	15	29	31	32	36	33	30	20	13	8.9	36
Tmin	-32	-30	-27	-18	-12	0.8	5	1.8	-7.4	-18	-25	-39	-38.8
Tsurface	-14	-8.6	1.3	12.5	22.7	28	28	26	17	6.7	-5.2	-12	8.5

**“ХҮР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**


/Хүснэгт 3/-ын эхний мөрнүүдэд цаг уурын Гурвантэс өртөөний агаарын температурын дундаж, үнэмлэхүй их болон бага утгын жилийн, сүүлийн мөрнүүдэд Ноён харуулын агаарын температурын дунджаар, үнэмлэхүй хамгийн их, бага утгын болон хөрсний гадаргын дундаж температурын жилийн явцыг тус тус үзүүллээ. Ноён сумын агаарын температурын хугацааны янз бүрийн зай дахь жилийн явцаас харахад энэ районд жилийн дундаж байдлаар агаарын температур нэмэгдсэн байна.

Агаарын дулаан хүйтэн жилийн дотор тэгш хэмтэй явцтай. Үүнийг үзүүлэх зорилгоор /Хүснэгт 3/-т, агаарын үнэмлэхүй хамгийн их, хамгийн бага температурын сар бүрийн утгыг үзүүлэв. Сарын үнэмлэхүй их, бага температур нь сарын дундаж температурын хэлбэлзэж болох хамгийн боломжтой хязгаарыг заах ба хүснэгтээс харвал дундаж утгаасаа хоёр тийшээ $14-28^{\circ}$ орчимд хэлбэлздэг байна. Агаарын температурын жилийн доторх явцыг тухайн сар бүрийн температурын утгын стандарт хазайлтын хамт /Зураг 4/-т үзүүлэв.



Зураг 4. Агаарын дулаан хүйтний жилийн явц


Агаарын температурын сарын дундаж температураар 33.2°C , хамгийн их, бага температурын дунджаар 38.7°C , үнэмлэхүй хамгийн их, бага температураар 74.8°C буюу жилийн доторх дулаан хүйтний хэлбэлзэл дунд зэрэг байна.



Зураг 5. Төслийн район орчмын жилийн дундаж агаарын температурын газарзүйн тархалт


2.2.2. Хөрсний дулаан хүйтэн:

Төслийн районд хөрсний гадаргын жилийн дундаж температур 8.5°C дулаан байна. 1 дүгээр сард хамгийн хүйтэн -13.5°C , 7 дугаар сард хамгийн дулаан 27.9°C орчим байна. Хөрсний гадарга дээр өвлийн улиралд агаарынхаасаа бага зэрэг хүйтэн, харин жилийн дулаан улиралд агаараасаа дулаан, ялангуяа зундаа $7-10^{\circ}\text{C}$ -ээр халуун.



Зураг 6. Агаар, хөрсний гадаргын сарын дундаж температурын жилийн явц


“ХҮР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН




Зураг 7. Хөрсний гүний температурын жилийн явц

Газрын гүнд температурын хуваарилалт нь тодорхой зүй тогтолтой. Зуны улиралд гүн ихсэхээр температур буурч, өвлийн улиралд гүн рүүгээ дулаарч, хавар, намар шилжилтийн байдалтай, тухайлбал 4, 10 дугаар сард дунд гүндээ (0.8, 1.2м) дулаан, хоёр тийшээ сэрүүссэн явцтай байна.


2.2.3. Төслийн район орчмын уур амьсгалын ирээдүйн төлөв:




Зураг 8. Агаарын температурын өөрчлөлт, (°C) 2020 онд



Зураг 9. Агаарын температурын өөрчлөлт, (°C) 2050 онд



Зураг 10. Хур тунадасны өөрчлөлт, (мм) 2020 онд



Зураг 11.Хур тунадасны өөрчлөлт, (мм) 2050 онд

**“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

3. ТӨСЛӨӨС ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Хур эрдэнэ баялаг” ХХК-ний “Баруун ноён уулын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийг хэрэгжүүлснээр байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг “Магадлан жагсаах” арга болон экспертийн үнэлгээний Матрицын аргыг хослуулан тодорхойлсон.

Магадлан жагсаах арга нь нөлөөлөх зүйл байгаа-байхгүй гэсэн зарчим дээр үндэслэж, сөрөг нөлөөллийг “х”-ээр, эерэг нөлөөллийг “+”-ээр тэмдэглэдэг. Нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийг илрүүлэхэд зориулагдсан бөгөөд нөлөөлөл нь шууд, шууд бус, буцах ба буцалтгүй, давхардах эсэхийг тодруулах, хугацааны хувьд урт, богино, эрчмийн хувьд хүчтэй эсэхийг үзүүлсэн.

Хүснэгт 4. Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа,
эрчмийг тодорхойлсон дүн

№	Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Сулавтар нөлөөлөх	Дунд зэрэг нөлөөлөх	Хүчтэй нөлөөлөх
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1. Байгалийн төрөл зүйн өөрчлөлт											
1	Газрын доорх урсацын өөрчлөлт	-				-	-			-	
2	Газрын доорх усны чанарын өөрчлөлт		-	-					-		
3	Ургамлын бүтцийн өөрчлөлт	-				-	-			-	
4	Хөрсний элэгдэл, эвдрэл	-				-		-			-
5	Геологийн тогтоцын өөрчлөлт	-				-		-			-
6	Зэрлэг, ан амьтдын орон зайн өөрчлөлт		-	-					-		
7	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			-					-		
2. Байгалийн нөөцийн ашиглалт											
8	Газрын гадаргын нөөц баялаг	-				-		-	-		
9	Бэлчээр, тэжээлийн байдал	-		-			-		-		

**“ХҮР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

10	Эрдэс түүхий эд, нөөц	-				-		-			-
11	Эрчим хүчний нөөц										
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт											
12	Ундны усны чанар өөрчлөгдөх		-	-	-			-		-	
13	Ундны усны нөөц хомсдох		-	-						-	
14	Агаарын бохирдол	-			-					-	
15	Хөрсний бохирдол		-		-		-			-	
16	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл		-			-	-			-	
17	Дуу, чимээ шуугианы нөлөөлөл	-			-				-		
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор											
18	Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх		-			-		-		-	
19	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх		-			-	-			-	
20	Тусгай хамгаалалттай газар, нутагт нөлөөлөх										
21	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
22	Археологи, палентологийн олдворт нөлөөлөх										
5. Нийгэмд үзүүлэх нөлөөлөл											
23	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх		+			+		+		+	
24	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх		+			+				+	
25	Хүн амын орлого нэмэгдэж өөрчлөгдөх	+				+		+		+	
26	Хүн амын тоо өөрчлөгдөх		-		-				-		
6. Эдийн засаг, байгаль орчин											
27	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх										
28	Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+		+	+		
29	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+				+		+	+		
30	Ажлын байр нэмэгдэх	+				+		+	+		
31	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+				+		
32	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх										
7. Бусад нөлөөлөл											

**“ХҮР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

33	Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс үүдэх хөрсний эвдрэл	-				-			-			
34	Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс ба грунтын усыг бохирдуулах	-				-				-		
35	Ахуйн хог, хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	-				-				-		
36	Хүчтэй салхи, тоосжилт	-				-						
Нөлөөллийн тоо ширхэг		Сөрөг	12	10	6	8	10	7	6	12	7	3
		Эерэг	5	2	0	1	6	0	5	4	3	0

Тайлбар: +/- Эерэг нөлөөлөл
/-/- Сөрөг нөлөөлөл

Дээрхи үнэлгээнээс үзэхэд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх нийт нөлөөллийн тоо нь гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл нь 22 байна. Үүнээс:

Шууд нөлөөлөл: Энд шууд үйлчлэх нөлөөлөл 17 байгаа бөгөөд эдгээрт нүүрс олборлох үйл ажиллагааны улмаас газрын доорх урсацанд өөрчлөлт орох, хөрсний элэгдэл эвдрэл үүсэх, геологийн тогтоц өөрчлөгдөх, ашигт малтмалын нөөц хомсдох, агаарын бохирдол үүсэх, ургамлан нөмрөг талхлагдах, бэлчээрийн даац багасах, хүчтэй салхи тоосжилт үүсэх гэх мэт сөрөг нөлөөлөл бий болж байна.

Шууд бус нөлөөлөл: Нөлөөллийн энэ ангилалд 12 зүйлийн нөлөөлөл хамаарч байна. Үүнд: Газрын доорх усны нөөц болон чанар өөрчлөгдөх, ургамлын бүтцийн өөрчлөлт, зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт, хөрсний бохирдол, байгалын үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх, хүн амын шилжилт явагдах зэрэг сөрөг нөлөөллүүд байна.

Өөрөө зохицуулагдах нөлөөлөл: Энд өөрөө зохицуулагдах 6 болзошгүй нөлөөллөөс газрын доорх ус болон чанар өөрчлөгдөх, зэрлэг ан амьтны орон зайн өөрчлөлт, уур амьсгалын өөрчлөлт, бэлчээр тэжээлийн байдал зэрэг багтаж байна.

Удаан хугацааны нөлөөлөл: 16 зүйлийн удаан хугацааны нөлөөлөл байгаагийн дотор газрын доорх урсацын өөрчлөлт, ургамлан нөмрөг өөрчлөлт, хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх, геологийн тогтоц өөрчлөгдөх, ашигт малтмал, газрын гадарга, эрдэс түүхий-эдийн нөөц хомсдох, хорт бодис усаар дамжин хүн амьтанд үзүүлэх нөлөөлөл, байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх, ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх, шороон зам харилцаа, уурхай

“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ”ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх зэрэг сөрөг нөлөөллүүд багтаж байна.

Богино хугацааны нөлөөлөл: Ийм хэлбэрийн нөлөөлөлд 9 зүйлийн нөлөөлөл орж байна. Үүнд: ундны усны горим, нөөц, чанар, агаарын бохирдол хөрсний бохирдол, дуу чимээ шуугианы нөлөөлөл, хүн амын шилжилт, ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчих зэрэг сөрөг нөлөөллүүд орж байна.

Буцаж нөлөөлөх: Энд 7 зүйлийн нөлөөлөл багтаж байгаагийн дотор газрын доорх урсацын өөрчлөлт, ургамлын бүтцийн өөрчлөлт, бэлчээр тэжээлийн байдал, хөрсний бохирдол, хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл, ландшафтын хэлбэр өнгө өөрчлөгдөх зэрэг болзошгүй сөрөг нөлөөллүүд багтана.

Буцалтгүй нөлөөлөл: Энэ төрлийн нөлөөлөлд 11 зүйлийн нөлөөлөл хамаарч байна. Энэ нь нүүрс олборлох үйл ажиллагааны улмаас хөрсний бүтэц, орд газрын геологийн тогтоц, нүүрсний хэмжээ багасан хомсдох зэрэг болзошгүй сөрөг нөлөөллүүдээс гаднадэд бүтэц хөгжих, хүн амын орлого нэмэгдэх, ажлын байр нэмэгдэх, ядуурал буурах зэрэг нь нийгэм, эдийн засгийн салбарт эергээр нөлөөлөх юм.

Хүчтэй нөлөөлөл: Энэ төрлийн нөлөөлөл 3 байгаа бөгөөд нүүрс олборлох үйл ажиллагааны улмаас хөрсний бүтэцэд өөрчлөлт орох, нүүрсний нөөцийн хэмжээ багасах, орд газрын геологийн тогтоц өөрчлөгдөх зэрэг хүчтэй нөлөөлөл гарч болзошгүй гэж үзэж байна.

Дунд зэргийн нөлөөлөл: Нөлөөллийн энэ ангилалд 10 зүйлийн нөлөөлөл орж байна. Үүнд: орд газарт байгалийн хөрс үгүй болж, орчны ургамал нөмрөг талхлагдан, бэлчээрийн талбай багасах, агаар бохирдох, ан амьтдын тархалт, тоо толгой өөрчлөгдөх зэрэг байгаль орчинд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүдийн зэрэгцээ, орон нутгийн орлого, орон нутгийн дэд бүтцийн хөгжил, хүн амын орлого нэмэгдэх зэрэг эерэг нөлөөллүүд хамрагдана.

Сулавтар нөлөөлөл: Сулавтар нөлөөллийн тоонд 16 зүйлийн нөлөөлөл орж байгаа бөгөөд нүүрс олборлох үйл ажиллагааны улмаас уулын чулуулгийн тогтоц, газрын доорх усны горим, хэмжээ, чанар өөрчлөгдөх, уур амьсгалын бичил өөрчлөлт, ан амьтдын орон зайн өөрчлөлт, дуу чимээ, шуугианы нөлөөлөл, хүн амын тоо өөрчлөгдөх сөрөг нөлөөллүүд байна.

Гол сөрөг нөлөөллийн үнэлэлтийн нарийвчилсан үнэлгээний дээрх хүснэгтээс үзэхэд нөлөөлөлд өртөгч экологийн орчин нь нүүрсний орд газрын хөрс, эрдэс баялаг, ургамлан

**“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ”ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

нөмрөг, бэлчээр, орчны агаар, бичил уур амьсгал бөгөөд эдгээр хамгийн их нөлөөлж болзошгүй үйл ажиллагаа нь хөрс хуулалт, нүүрс олборлолт, тээвэрлэх үйл ажиллагаа, машин техникийн дуу чимээ, доргио зэрэг болно.

**“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

4.1 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний биелэлт:

“Хур эрдэнэ баялаг” ХХК нь 2023 оны БОМТ-нд байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах осол, эрсдэлийн менежментийн арга хэмжээнд нийт 13-н ажлыг төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хэрэгжилтийг товч байдлаар дурдав.

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний хэрэгжилт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэлтийн шалгуур
	1	2	3	4	5
1	Агаарын чанар	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор дулааны улиралд тогтмол усалгаа хийх;	Уурхайн технологийн зам, туслах зам, нүүрс агуулах талбай;	Тогтмол	"Хур эрдэнэ баялаг" ХХК нь уурхайн технологийн зам, гаалийн талбайн тоосжилт болон ногоон байгууламжийн арчилгаа усалгааг хийх зориулалт бүхий 4 усны цистернтэй. Эдгээр техникүүд нь уурхайн шүүрлийн усыг ашиглан технологийн зам, хөрсний овоолго болон гаалийн хяналтын талбайг тогтмол усалж, тоосжилтыг дардаг.
		Тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар арчилгааг хийх, тэмдэг тэмдэглэгээг сайжруулан нэмэлтээр байршуулах;	Уурхайн технологийн зам, туслах зам;	Улиралд нэг удаа	Уурхайн бүс болон технологийн замууд дээр зорчих хөдөлгөөнд хурдны хязгаарыг тусгасан дүрэм, аюулгүй ажиллагааны зааварчилгаа батлуулан хяналт тавьж ажиллахаас гадна шаардлагатай хэсгүүдэд замын тэмдэг, тэмдэглэгээг байрлуулан ХАБ-ын ажилчид хяналт тавин ажиллаж байна.

**“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ”ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

		Дотоод тээврийн зам болон технологийн зам дээр зорчих хөдөлгөөнд оролцож байгаа автомашин болон уулын хэсгийн техникүүдийн хөдөлгөөнд хурдны хяналт тавих,	Уурхайн технологийн зам, туслах зам, нүүрс агуулах талбай;	Тогтмол	Уурхайн дотоод хэрэгцээнд дагаж мөрдөхөөр "Уурхайн замын хөдөлгөөний дүрэм"-ийг 2023.06.16-нд батлуулан нийт ажилчид, ИТА нар, удирдлагуудад танилцуулж, сургалт орсны дагуу уг дүрмийн хэрэгжэлтийг хангаж ажиллаж байна.
		Ажилчдыг эрүүл ажиллах, амрах орчинг бүрдүүлэх зорилгоор уурхайн тосгоны ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, тоосжилтоос хамгаалан зүлэгжүүлэх;	Уурхайн тосгон;	Нэг удаа	Уурхайн ажилчдын тосгонд 2023.05.10-нд 2800 м ² олон настyg тариалах ажлыг хийж гүйцэтгэхээс гадна 700 мод бутыг арчилж тордон ургуулж байна.
2	Гадаргын болон газар доорхи ус	Уурхайн ундны усны хэрэгцээ тогтмол бүртгэх, ашиглах усны хэмжээг зорилтод түвшинд байлгах;	Уурхайн тосгон;	Тогтмол	Уурхайн ундны усны хэрэгцээг тогтмол бүртгэж, сар болгон хэрэглэсэн усны тайлан мэдээг Ноён сумын байгаль хамгаалагчид хүргүүлдэг.
		Хөв цөөрөм байгуулах ажлын хийж гүйцэтгэх;	*	1 удаа	Ноён сумын Ганзагад багийн "Цоохондойн задгай усыг сувагчлан засварлах, цөөрөм байгуулах ажил"-ын зураг төслийг "Тэлмэн констракшн" ХХК-аар 2022 онд гүйцэтгүүлэн, 2023 онд "Цоохондойн задгай усыг сувагчлан засварлах, цөөрөм байгуулах ажил"-ыг 2023.10-11 сар хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэн холбогдох байгууллагуудад хүлээлгэж өгөхөд бэлэн болоод байна.

**“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

		Уурхайн ногоон байгууламж усалгаанд зориулж ус ашиглах;	Уурхайн хэсэг;	2, 3-р улирал	2023.06 сараас эхлэн уурхайн хэсгээс шүүрлийн ус гарч эхэлсэн тул холбогдох байгууллагууд мэдээ хүргэн сумын байгаль хамгаалагчтай хамтран баталгаажуулсан тоолуурыг суурилуулсан. Мөн сар тутамд шүүрлийн усыг шавхан зайлуулах усны төлбөрийг төлж барагдуулан ногоон байгууламж, зам арчилгаанд уурхайгаас гарсан шүүрлийн усыг ашиглаж байна.
		Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах;	Уурхайн нийт ажилчдад;	2023.06.25, 2023.08.11	Уурхайн нийт ажилчдад усны зохистой хэрэглээ сурталчлах зорилгоор усны байгальд орших байдал, усны нөөц, ус ашиглалт, усны бохирдол, усны зохистой хэрэглээний талаар мэдээлэл өгч сургалт явуулсан. Мөн Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас “ӨӨРЧЛӨЛТИЙГ ХУРДАСГАЯ” уриан дор Ноён сумын төвд зохион байгуулсан 3 сумын дунд ангийн сурагчдын дунд зохион байгуулсан дэвжээ тэмцээнд дэмжлэг үзүүлэн ажилласан.
3	Хөрсөн бүрхэвч	Уурхайн олборлолтод өртөх талбайгаас шимт хөрсийг хамгаалах зорилгоор хадгалах талбайд стандартын дагуу овоолго үүсгэх;	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд;	Жилийн турш	2019-2023 оны хооронд нийт 115200 м ³ шимт болон шимэрхэг хөрсийг хадгалж, хамгаалах зорилгоор 3 метрээс өндөргүй, 3 га талбайд овоолго үүсгэн олон наст ургамлыг тарих туршилтын ажлыг хийж гүйцэтгэв.

**“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

		ШТМ хөрсөнд алдагдахаас сэргийлэх;	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд;	Жилийн турш	Техникийн хаягдал тос, тосолгооны шингэнийг хүлээлгэн өгөх гэрээг “Алтан оршихуй групп” ХХК-тай 2023-04-18-ны өдөр байгуулан Шатах тослох материалыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, үйл ажиллагааг гэрээний шаардлагын дагуу явуулж байна. Техник, тоног төхөөрөмжүүдээс гардаг ШТМ-ын хаягдлыг бүртгэн, засвар механикийн хэсэгт хадгалах зориулалт бүхий тусгай талбайг хийж гүйцэтгэсэн.
4	Газрын гадарга	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө" Газар хөндөх зөвшөөрөл авах, олгох, бүртгэл хөтлөх";	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд;	Жилийн турш	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж, аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө газар хөндөх зөвшөөрлийн маягт бөглөн зөвшөөрөл авч ажиллаж байна.
5	Ургамлан нөмрөг	Байгаль орчны доройтол, цөлжилтийг бууруулах зорилгоор Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" хөдөлгөөний хүрээнд Баяндалай суманд мод тарих ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх;	*	2 болон 4-р улиралд	Өмнөговь аймгийн Баяндалай сумын 100 жилд зориулан тус сумын наадмын талбайн хойно, наадмын талбай дотор нийт 5500 мод тариалах ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн 5 сарын хугацаатай байнгын усалгаа арчилгааг хийж 2023.10.28 цэнэг усалгааг хийн ажилчиддаа буулгасан. Өвлийн улиралд тухайн талбайд хяналт тавихаар 2 ажилчинг ростерлон ажлуулж байна.
6	Амьтны аймаг	Уурхайн үйл ажиллагаа явуулж буй газрын ойролцоо ховор зүйлд тооллогддог амьтдын тоо толгойд хяналт тавьж, мэдээг хөтлөх;	Уурхайн бүс;	Тогтмол	“Есөн эрдэнэ” ХХК гэрээт харуул хамгаалалтын албатай хамтран уурхай, уурхайн тосгоны 5 км радиуст ховор ан амьтанд хяналт тавин мэдээ хөтлөн, тоо толгойг сумын холбогдох албан тушаалтанд мэдээллэдэг.

**“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ”ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

		Ховор зүйлийн амьтдын хөл газарт улирлын нөхцлөөс хамааран биотехникийн аргаар хэмжээ авах;		1 болон 4-р улирал	Идэш тэжээлийн хомстолд орсон ан амьтдад 1 сарын 15-ны өдөр уурхайн эдэлбэр газрын 5км радиуст мөс тавьж өгсөн. 4 сарын 17-ны өдөр Ноён сумын байгаль хамгаалагч Болдмаа орон нуггийн идэвхтэн байгаль хамгаалагч нартай хамтран Ганзагад багийн нутгаар 300 гаруй км явж, Халбас, Гэнгэдийн гол, Цагаан толгой, Шивээт хүрэн, Улаан шал зэрэг газруудаар 20 орчим цэгт өвс тараан байршуулсан.
--	--	---	--	--------------------	---

**“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ”ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

4.2 Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт:

Хүснэгт 6. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Биелэлтийн шалгуур
1	Техникийн нөхөн сэргээлт	Уурхайн ахилт, бүтээн байгуулалт, зам талбайн үйл ажиллагаанд өртөх шимт хөрсийг хуулж, тусгай талбайд овоолго үүсгэх;	га	Тогтмол	2023 онд хөрсний гадаад овоолгын тэлэлтийн талбай, технологийн замуудыг шинээр байгуулсан. Нийт 25000 м ³ шимт хөрсийг хуулж шимт хөрсний овоолгыг 3 м хүртэл өндөртэйгээр тэлэн өргөжүүлсэн. /Шинээр нэмэгдсэн талбай 0.2 га./
2	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний овоолгыг салхины элэгдлээс хадгалж, хамгаалах зорилгоор олон наст ургамлыг туршилтаар тариалах	га	2, 3 дугаар улирал	Шимт хөрсийг хадгалж, хамгаалах зорилгоор туршилтаар олон наст болох саман ерхөг - <i>Agropyron christatum</i> , соргүй согоовор- <i>Bromus inermis</i> , 2 төрлийн олон настын үрийг тарих ажлыг хийсэн. Говийн нөхцөлд олон наст ургамлыг 5 дугаар сараас эхлэн тарих төлөвлөгөө гарган 2023 оны 6 дүгээр сарын 1-с эхлэн бэлтгэл ажил болоод үрлэгээний ажлыг шат дараалалтай хийж гүйцэтгэсэн.

**“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ”ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

4.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлт:

Хүснэгт 7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хэрэгжилт

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Биелэлтийн шалгуур
	1	2	3	4	5
1	Цагаан толгойн зэрлэг ан амьтны тоо толгойд хяналт тавих;	Хяналт тавих;	Цагаан толгойн тал	Улиралд 1 удаа	Цагаан толгойн тал руу жигд тархсан амьтны төрөл зүйл нь хар сүүлт зээр байна.
2	Цагаан толгойн талд нарны үүсгүүрээр автомат худаг гаргаснаар тухайн орчны хар сүүлт зээр амьдрах орчиндоо тогтвортой байрших нөхцөлийг бий болгох;	Зэрлэг ан амьтанд зориулсан нарны үүсгүүрээр ажиллах автомат худаг гаргах.	Цагаан толгойн тал	Нэг удаа	Байрлал: Ноён сумын Ганзагад баг, Цагаан толгойн талд 2023.09.17 өдөр худаг гаргах ажлыг гүйцэтгэсэн. Өргөрөг:42°28'40.0" Уртраг: 101°59'45.1"
3	Цагаан толгойн талын ургамлын аймаг, ургамлан бүрхэвчийг хамгаалах;	Үр түүж бэлтгэх, үрийг стандартын дагуу хадгалах;	Цагаан толгойн тал	2, 3-р улиралд	8 болон 9 сард худаг гаргах ажилтай хамтатган Цагаан толгойн талын ургамлын аймгийн ургалтыг тандах, тухайн хэсгийн ургамлын үрлэлтийг гүйцмэгц үр түүх зорилгоор 5-6 удаагийн тандалд хийсэн бөгөөд хараахан үр түүж бэлдэж чадаагүй.

**“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ”ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт:

2022 онд уурхайн ойр орчмын 13 айлтай хамтран ажиллах гэрээг хийж гүйцэтгэсэн бөгөөд гэрээний хугацаа дуусгавар болоогүй байгаа болно.

Хүснэгт 8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Биелэлтийн шалгуур
1	13 айл	Нөхөн олговрын гэрээ хийх;	Нөлөөллийн бүсийн айлууд;	1 удаа	2022 онд Уурхайн ойр орчмын 13 айлтай нөхөн олговрын гэрээг хийж гүйцэтгэсэн.

**“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

4.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт:

“Хур эрдэнэ баялаг” ХХК-ийн “Баруун ноён уул” нүүрсний уурхайн лицензийн талбайд 2012 онд “Шинжлэх Ухааны Академи Археологийн Хүрээлэн” археологийн хайгуул хийгдэж, археологийн олдвор илрээгүй болно.

2023 оны 4 болон 6-р саруудад Палеонтологийн хайгуул судалгааны ажил, Угсаатан зүйн авран хамгаалах, тандан судалгааны ажлын гэрээг Шинжлэх ухааны академийн харьяа бүхий хүрээлэнгийн удирдлагуудтай гэрээ хийн тайлан дүгнэлтийг хүлээн авсан.

Хүснэгт 9.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Биелэлтийн шалгуур
	1	2	3	4	5
1	Палеонтологийн дурсгал	*	Лицензийн талбай	1	ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнтэй 2023.04.19-ний өдөр хийсэн гэрээний дагуу хайгуулын ажлыг хийж гүйцэтгүүлэн тайлан болон дүгнэлтийг хүлээн авсан.
